

МУИС-ийн ОЮУТАН МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ

Мэдээ-4

МУИС дотуур байраа орлого олох эх үүсвэр биш харин оюутан аюулгүй, аятай тохитой орчинд амьдарч, амжилттай суралцах урьдчилсан нөхцөл гэсэн бодлого барьдаг.

- МУИС нь гадаад оюутны 1 байр, дотоод оюутны 5 байртай. 2014-2015 оны хичээлийн жилд 431 өрөөнд 1724 оюутан хүлээн авахаар бэлтгэл ажлаа ханган оюутнуудаа байрлуулаад байна.
- Албан ажлын болон гадны айл амьдарч байсан өрөөг чөлөөлөх замаар 47 өрөөнд 126 оюутан нэмж байрлуулах боломжтой болж МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрийн шаардлагатай оюутнууд дотуур байранд амьдрах нөхцөл бүрдлээ.
- Өнгөрсөн хичээлийн жилд дотуур байрнаас 518 сая төгрөг төвлөрсөнийг бүхэлд нь оюутны дотуур байрны орчин нөхцөл, тохь тухыг нэмэгдүүлэхэд зарцуулсан байна. 2014-2015 оны хичээлийн жилд 741.8 сая төгрөгний засвар үйлчилгээ тохижилт хийснээс заримыг дурдвал:
 - Оюутны 1-р байрны фасад, дээвэр, Оюутны 3 ба 5-р байрны хар цаасан дээвэр, фасад, гадна хашааг зассан нь өнгө үзэмжийг нэмэгдүүлж, таазнаас ус гоожих зэрэг таагүй явдал эцэс болов.
 - МУИС-ийн Оюутны 2 ба 3-р байрны цонх сольсноор дулаан алдалтыг эрс багасгах боломж бүрдлээ.
 - Оюутны 1,2,3,4-р байрны ялтсан бойлер бүрэн солисноор дулаан өвөлжиж, тухтай амьдрах боломжтой боллоо.
 - Бүх оюутны байрны гал тогооны өрөөнд цахилгаан зуух байрлуулахаар хөрөнгийн эх үүсвэрийг шийдэж, худалдан авалтыг зохион байгуулахаар болсон нь галын аюулаас урьдчилан сэргийлж, өрөөндөө хичээл номоо давтах нөхцөл бүрдэв.
- Энэ хичээлийн жилд дотуур байрнаас одоогийн байдлаар нийт 519 гаруй сая төгрөг төвлөрөөд байгаа бөгөөд цаашдаа оюутны амьдрах орчин нөхцлийг сайжруулахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлэн хийнэ.
- Цаашид нэг өрөөнд амьдрах бакалаврын оюутны тоог цөөлж 3 болгох, магистр доктор оюутныг хоёроороо амьдрах нөхцлийг судалж хэрэгжүүлэхээр зэхэж байна.
- Богино хугацаагаар ирж байгаа гадаадын оюутнуудыг байрлуулан орлого олж түүнээ байрны тохижилтонд зарцуулах нөхцөл бүрдүүлнэ.
- Богино хугацаагаар төвийн бүрэлдэхүүн сургуулиудад сурах Орхон, Завханы оюутнууд, амьдралын гэнэтийн асуудлаас болж дотуур байранд амьдрах шаардлага тулгарсан оюутны хэрэгцээнд зориулан цөөн тооны өрөөг ашиглах болно.

Түүнчлэн хувцас угаалгын өрөөнүүд бэлдэж, угаалгын болон хатаагч машинаар хангах, оюутны байрны уншлагын танхмийг ном сурах бичиг, сэтгүүлээр хангах, эмнэлгийн үйлчилгээг байраар үзүүлэх ажлыг зохион байгуулахаар болж байна.

2014-2015 оны хичээл жилд МУИС нь бакалаврын болон Ерөнхий суурийн хичээлийн сургалтын хөтөлбөрөө бүрэн шинэчилж баталлаа.

- МУИС-ийн захирлын 2014 оны 7 дугаар сарын 31 -ний өдрийн "Бакалаврын хөтөлбөр, ерөнхий суурь хичээлийг батлах тухай" А\259 тоот тушаалаар холбогдох хөтөлбөрүүд батлагдлаа.
- НҮБ-ын ЮНЕСКО, БШУЯ-наас гаргасан шаардлагад нийцсэн бакалаврын зэрэг олгох мэргэжлийн 61 хөтөлбөр, ерөнхий суурь хичээлийн 94 хичээлийн хөтөлбөрийг боловсруулж баталсан байна.
- Хөтөлбөрийг боловсруулахад хөтөлбөрийн 35 хороодод МУИС-ийн докторын зэрэгтэй багш нарын дийлэнх болох 260 гаруй эрдэмтэн профессорууд оролцсон бөгөөд 150 гаруй багш, ажил олгогчдын төлөөлөл экспертээр ажилласан болно.

2014-2015 оны хичээлийн жилд оюутан суралцагчид бүртгэлийн Си Си системээр судлах хичээлээ сонгосон байдал:

- 2014-2015 оны хичээлийн жилийн намрын улиралд МУИС-ийн бүрэлдэхүүн ШУС, БС, ХЗС, ХШУИС болон ОУХНУС болон Орхон, Завхан сургуулиудын хэмжээнд бакалаврын өдөр, орой, эчнээ хөтөлбөрт нийт 20979 мянган оюутан бүртгэлтэй байгаагаас идэвхтэй суралцаж байгаа 16565 оюутан, жилийн чөлөө авсан зэрэг идэвхгүй статус бүхий 3142 оюутан байна.
- 2014-2015 оны намрын улиралд хичээл сонгосон нэг оюутанд дунджаар 16.0 багц цаг ноогдож байгаа бөгөөд өнгөрсөн 2013-2014 оны хаврын улиралд энэ тоо 15.5 багц цаг байжээ.
- Өдрөөр сурдаг нэг оюутны сонгосон дундаж багц цагийн хэмжээгээр БС-16.0 бц, ОУХНУС-16.5 бц, ХЗС-16.7 бц, ХШУИС-15.8 бц, ШУС:БУС-15.9, ШУС:НУС-16.1 бц, ШУС:ХУС-15.5бц, Орхон сургууль 16.1 бц болон Завхан сургууль-15.5 бц байна.

Энэ хичээлийн жилийн намрын улирлын хичээлийн хуваарь, тулгарсан бэрхшээл:

- Офисын зориулалттай болон засвар үйлчилгээ хийгээгүйгээс үүдэн сургалтанд ашиглагдаггүй байсан өрөө тасалгааг цэгцэлснээр нийт 766 м2 бүхий 13 хичээлийн танхим шинээр бий болж 700 гаруй оюутан хичээллэх сургалтын орон зайтай болов.
- МУИС-ийн хэмжээнд анх удаа нэгдсэн байдлаар хичээлийн хуваарь хийсэн нь анги танхмийн ашиглалтыг үр өгөөжтэй болгож, ачааллыг жигдлэх боломж өглөө. Өмнөх жилүүдэд хичээлийн хуваарийг бүрэлдэхүүн сургууль бүр тусдаа хийдэг байснаас үүдэн анги танхмийн ашиглалт харилцан адилгүй, зарим байранд анги танхим хүрэлцэхгүй байхад зэргэлдээ хичээлийн байранд ашиглалтгүй анги танхим олноор байх нь ердийн зүйл байсныг өөрчилж чадлаа.
- 2014 оны 9 дүгээр сарын 22-ны байдлаар ажлын өдрийн өглөөний 09 цаг 00 минутаас оройн 18 цаг 50 минутын хооронд МУИС-ийн 1,2,3,4,5,6,7,8 дугаар байрны нийт 905 анги танхмийг нэгдсэн хуваарьт оруулснаар эдгээр анги танхмийн ачаалал дунджаар 53.14 хувьд хүрчээ. 10 дугаар сарын 1-нээс магистр, докторын хичээл эхлэхтэй холбогдон анги танхмийн ашиглалтын хувь өөрчлөгдөнө. Хичээлд ноогдох анги танхмийн цагийн ачаалал ийнхүү буурснаар багш нар зөвлөгөө өгөх, оюутны бие даан суралцах, бүлгээр ажиллах орон зай нэмэгдэж байгаа юм.

- Хичээлийн хуваарийг нэгдсэн байдлаар зохиосон, шинэ анги танхим нэмэгдсэн түүнчлэн ерөө дугаарлалт хаягжилт жигдрээгүй, шинэ мэдээллийг бүртгэлийн системд цаг тухайд нь оруулаагүй зэргээс үүдэн 2014-2015 оны хичээлийн жилийн намрын улиралд хичээл сонгох, баталгаажуулах үйл явцад доголдол гарав. Ялангуяа Си Си системийг сургалтын шинэ шаардлагад нийцүүлэх болон техник тоног төхөөрөмжийг шинэчлэх ажил хоцрогдсон, зарим талаар сургалтын албаны ажилтнуудын дадлага туршлага дутагдсан зэргээс шалтгаалан цөөнгүй хүндрэл учирсан. МУИС-ийн захиргааны зүгээс Мэдээллийн технологийн албаны (МТА) удирдлагатай хариуцлага тооцох, сургалтын алба, хичээлийн байрны зохион байгуулагчид, МТА-ны мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсэг гаргаж ажиллуулах зэргээр гарсан хүндрэл бэрхшээлийг засч залруулах арга хэмжээг авснаар сургалтын үйл явц хэвийн болж жигдэрлээ. Мөн бүртгэлийн системийн хүчин чадлыг нэмэгдүүлэхийн тулд өндөр хүчин чадалтай сервер авахаар болж санхүүжилтийг шийдэж, нээлттэй тендер зарлаад байна.

Оюутны хичээл сонгох үйл явц: онцлог, тулгарсан хүндрэл бэрхшээл:

- Энэ хичээлийн жилд шинээр элссэн оюутнууд ерөнхий суурийн 8 чиглэл салбарын 279 багц цаг бүхий 94 хичээлээс 15-21 хүртэл багц цагтай 5-7 хичээлийг 100 хувь чөлөөт сонголтоор хийв. Харьцуулахад, өмнөх жилүүдэд ерөнхий эрдмийн хичээлийн 24 багц цагийн хүрээнд 16 хичээлээс 17 багц цагтай 5 хичээлийг сонголтгүй заавал үздэг, харин 7 багц цаг бүхий 2-3 хичээлийг сонгон судалдаг байлаа.
- Бүрэн сонголттой анх учирсан оюутнуудын хувьд хичээлээ сонгож, суралцах төлөвлөгөөгөө гаргахдаа туршлагагүйтэх, олон удаа сонголтлоо өөрчлөх зэргээр бүртгэлийн системийн ачааллыг нэмэгдүүлж байсан нь нийт оюутны хичээл сонгох баталгаажуулахад сөргөөр нөлөөлсөн. Оюутанд туслан зөвлөх үүднээс МУИС-ийн сургалтын нэгдсэн албаны(СНА) зүгээс а) Ерөнхий суурийн хичээл хэрхэн сонгох заавар: хэвлэмэл болон шторк байдлаар, б) Ерөнхий суурьтай холбоотой түгээмэл асуулт хариулт: хэвлэмэлээр, в) Ерөнхий суурийн хичээлүүдийн тодорхойлолт: хэвлэмэлээр, г) Бүртгэлийн систем ашиглах заавар: хэвлэмэл болон шторк байдлаар бэлдэж оюутандаа хүргэв. Түүнчлэн бүх оюутнуудад “МУИС-ийн оюутны гарын авлага” үнэ төлбөргүй тарааж, 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдөр шинэ оюутныг чиглүүлэн танилцуулах өдөрлөгийг МУИС даяар зохион байгуулж, СНА-ны 70 гаруй ажилтан зөвлөгөө өгч ажилласан нь зохих үр дүнгээ өглөө.
- Сонголт хийхэд шаардлагатай мэдээллээр оюутныг хангах үүднээс 2014 оны 11 болон 12 дугаар саруудад а) Ерөнхий суурийн 8 салбар чиглэлийн 94 хичээлийн танилцуулга б) Бакалаврын зэрэг олгох мэргэжлийн хөтөлбөрүүдийн танилцуулгыг МУИС даяар зохион байгуулахаар бэлтгэлээ хангаж байна.
- 2014-2015 оны хичээлийн жилд магистрын хөтөлбөрт 857, докторын хөтөлбөрт 131 хүн бүртгүүлж, шалгалтанд орсон бөгөөд хичээлийн хуваарь сонголтыг бүртгэлийн системээр анх удаа бүрэн хийж хэрэгжүүлж байна.
- БШУЯ-наас магистр, докторын сургалтын журмыг шинэчлэн баталсантай холбогдуулан магистрын 107, докторын 44 хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, магистр докторын оюутны гарын авлага бэлдэж хэвлүүлэх зэрэг ажил хийгдэж байна. Мөн МУИС-ийн стратеги төлөвлөгөө, дүрмийн шинэчлэлийн хүрээнд “Сургалтын нэгдсэн журам”-ын төслийг боловсруулж, хэлэлцүүлэгт оруулахаар зэхэж байна.

МУИС-ийн шинэчлэлийн эдийн засгийн үр нөлөө:

- Шинэ бүтэц зохион байгуулалтын дүнд үр ашиггүй зардлыг эрс бууруулах замаар төвлөрсөн сангийн зардлаас 1,8 тэрбум төгрөг хэмнэлээ.
- МУИС-ийн төсвийн 2014 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр орлого 105,1 хувийн, зарлага 102,2 хувийн үзүүлэлттэй болж, 2013 оны байдлаар ЭЗС (хуучнаар) 528,7 сая төгрөгийн, МТС (хуучнаар) 129,1 сая төгрөгийн алдагдалтай байсан бол энэ хичээлийн жилд дээрх алдагдлаасаа гарч төсөв эрүүлжлээ.
- Төсвийн хэмнэлтийн дүнд сургалт, эрдэм шинжилгээний орчинг сайжруулахад зориулсан өөрийн хөрөнгөөр хийдэг засварын хэмжээ өслөө. МУИС өөрийн хөрөнгөөр хийдэг засварын ажилд 2013 онд 740,4 сая төгрөг зарцуулж байсан бол 2014 онд өмнөх жилээс 2 дахин их буюу нийт 1,4 тэрбум төгрөг зарцууллаа.
- Эрдэм шинжилгээний төсөл, хөтөлбөр, гэрээт ажлын орлого өмнөх оноос 758,1 сая төгрөгөөр, энэ оны төсвөөс 369,9 сая төгрөгөөр өссөн.
- МУИС-ийн нэрэмжит тэтгэлэгийг өнгөрсөн хичээлийн жилээс олгож эхлээд давхардсан тоогоор 47 оюутанд 29,4 сая төгрөгийн тэтгэлэг олгосон бөгөөд гадаад дотоодын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан оюутны тоо 300 гаруй болжээ.
- 2014 онд Туркийн Станбул хотод болсон Измерийн их сургуулийн нэрэмжит Олон улсын эрдэм шинжилгээний хурал, түүнчлэн БНХАУ-ын Хөх хотод зохион байгуулагдсан Оюутны чуулга уулзалтанд нийт 14 оюутан оролцсоны зардалд 7,1 сая төгрөг зарцуулжээ.
- МУИС-ийн шинэчлэлийг дэмжсэн шинэ хөрөнгө оруулалт нэмэгдэв. Тухайлбал, 2014 оны төсвийн жилд улсын төсвийн болон “Дээд боловсролын шинэчлэл төсөл”-ийн санхүүжилтээр нийт 4,7 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэх боломжтой болов. Үүнд:
 - Е-номын сангийн барилгад 2 тэрбум төгрөг
 - Сургалт судалгааны лаборатори байгуулахад 1,5 тэрбум төгрөг
 - Оюутны амьдрах орчинг сайжруулахад 654,2 сая төгрөг
 - Оюутны нэг цэгийн үйлчилгээнд 169 сая төгрөг
 - Завхан сургуулийн спорт заалны засварт 73 сая төгрөг
 - Интернетийн хурдыг 139Mbps-151Mbps-хүргэсэн бөгөөд оюутны байрны өрөөнүүдийг утсан сүлжээний интернеттэй болгох, хичээлийн байруудын утасгүй сүлжээний өргөтгөл хийх зэрэг ажлуудыг эхлүүлсэн нь энэ ондоо дуусна.
 - Мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах, серверүүдийн өрөөний автомат хамгаалалтын тоноглолд 14 сая төгрөг зарцуулсан. Төв серверийн өргөтгөлын тендер зарлагдсан бөгөөд үүний дүнд сургалтын бүртгэлийн системийн найдвартай байдал өснө.

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

СУРГАЛТЫН НЭГДСЭН АЛБА
 МУИС-ийн хичээлийн I байр,
 Их Сургуулийн гудамж - 1, Бага тойруу,
 Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар
<http://num.edu.mn>
our@num.edu.mn